



ДЭРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Н.МЯДАГМАА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг
Сайнцагаан сум Нарлаг баг
Утас 70-59-24-33 70-59-22-08 70-59-32-03
E-mail: dundgovi@audit.gov.mn

09/60 № ҮАГ-НАГ/2017/01-НА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 19.1-д заасны дагуу аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөгөөр Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад нийцлийн аудит хийх явцад 79,901,007.00 /Далан есөн сая есөн зуун нэг мянга долоон төгрөг / төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 49,901,007.00 төгрөгийн өртөгтэй "Дэрэн, Дэлгэрцогт сумын ургамалжуулах талбайн тэжээлийн үйлдвэр нэмэгдүүлэх ажил"-ын төсөв зохиогч нь гүйцэтгэгч хуулийн этгээдэд зөвлөхөөр ажиллахаар тендерийн материалд ирүүлсэн байхад үнэлгээний хороо тус тендерийг шалгаруулсан. Аудитын явцад гүйцэтгэсэн ажилтай танилцахад тендерийн баримт бичигт тусгагдсан ажлаас зөрүүтэй, үр дүн муутай байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5-д **/тендерт оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;/** гэж заасныг.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 30,000,000.00 төгрөгийн төсөвт өртөгтэй **"Инженерийн хийцтэй худаг"** гаргах ажлын худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгохдоо босго үнийг мөрдөлгүй шууд худалдан авалт хийсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах /ТБОНӨХБАҮХА/ тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д **/Бараа ажил үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно/, 8 дугаар зүйлийн 8.7.1-д /тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох;/** гэж заасныг тус тус зөрчсөн байна.



1301600712

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.5-д /Байгуулсан гэрээ, хэлцэл мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлага, нөгцөлийг хангаагүй/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээг батлахдаа иргэд олон нийтийн саналыг авсан, нийтийн эрх ашигт нийцэхүйц болон бусад шаардлагыг хангасан хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТ хууль, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах.

Албан шаардлагын биелэлтийг 2017 оны 04 дугаар сарын 25-ны дотор аймгийн Аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Дэрэн сумын Засаг дарга Н.Мядагмаа, Засаг даргын орлогч И.Нямдаваа, санхүүгийн албаны дарга С.Цогтбаатар нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангаагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.